БАТЛАВ.

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.АЛТАН-ОД

ЗАМЫН-ҮҮД БООМТЫН ШУУДАН, ЛОГИСТИКИЙН ТӨВИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны ... сарны ... өдөр Дугаар Улаанбаатар хот

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ		
1	Ажлын нэр	Шуудан, логистикийн төвийн ерөнхий төлөвлөлт, техник эдийн засгийн үндэслэл боловсруулан батлуулах
2	Захиалагч	**Нэр:** "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам" **Хаяг:** Сүхбаатарын талбай - 1, Энх тайвны өргөн чөлөө, 1-р хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар 15160-0012, Монгол Улс. **Цахим шуудан:** info@mddc.gov.mn
3	Төслийн зорилго	Монгол Улсын засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан хүрээнд Замын-Үүд боомтын чөлөөт бүсэд Шуудан, логистик тээврийн терминалыг байгуулснаар Замын-Үүд боомтоор нэвтрэх цахим худалдааны бараа бүтээгдэхүүн, шуудангийн илгээмжийг гаалийн хяналтаар бүрэн оруулах, албан ёсны шугамаар хил гаалиар нэвтрүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгож Монгол улсын газрын шуудан, цахим худалдааны урсгалыг нэмэгдүүлэх юм.
4	Төслийн байршил, талбай	Дорноговь аймаг, Замын-Үүд сум
5	Төслийн эрх зүйн үндэслэл:	"Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн дөрөвдүгээр бүлгийн 4.1.16-д "Дамжин өнгөрүүлэх тээвэр, худалдаа, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг тээвэр, логистик, хилийн дэд бүтцийн хамт байгуулан эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангана" гэж, 4.4.4-д "Эдийн засгийн коридор бий болгох гурван талт хэлэлцээрийг боловсронгуй болгож, Монгол Улсын тээвэр, логистик, хот байгуулалт, хил дамнасан худалдаа, аялал жуулчлалын дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлнэ" гэж, 4.4.11-д "Гадаад, дотоод зах зээлүүдтэй холбогдох зорилгоор тээвэр логистикийн нэгдсэн сүлжээг хөгжүүлэх, дэд бүтцээ үр өгөөжтэй байлгахын тулд дамжин

		өнгөрөх тээврийн гэрээ хэлэлцээрүүдийг сайжруулж хэрэгжүүлнэ" гэж, Шинэ сэргэлтийн бодлого"-ын 3 дугаар хавсралтад "Шинэ сэргэлтийн бодлого"-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалтын 6 дугаарт Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх ачаа тээврийн терминалуудыг байгуулах төсөл /Гашуун сухайт, Шивээ хүрэн, Бичигт, Ханги, Эрээнцав, Арц суурь, Алтанбулаг, Замын-Үүд/ гэж, Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.2.22. "Бүсүүдийн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, тээвэр логистикийн сүлжээг сайжруулж, улсын болон орон нутгийн чанартай авто зам, төмөр замын дэд бүтцийг бүтээн байгуулж, боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлнэ" гэж, 3.3.2.1. "Боомтын шинэчлэлийг үргэлжлүүлж, боомтын үйл ажиллагааг цахимжуулах замаар "Ухаалаг гарц"-ыг бүрэн ашиглалтад оруулна" гэж тус тус туссан.
II. ЗАМЫН-ҮҮД БООМТЫН ШУУДАН, ЛОГИСТИКИЙН ТӨВИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ		
6	Төслийн боловсруулалт	Техник, эдийн үндэслэл боловсруулах судалгааны тайланд дараах асуудлыг тусгасан байна. Үүнд: 1. Зах зээлийн судалгаа: • Эдийн засгийн макро орчны судалгаа; • Эрэлт, нийлүүлэлтийн шинжилгээ; • Замын үүд боомтын нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдлын шинжилгээ; • Замын-Үүд боомтын цахим худалдааны бараа, шуудан ачаа, тээвэр логистикийн өнөөгийн байдлын шинжилгээ. 2. Байршил зүйн судалгаа: • Инженер геологийн нөхцөл; • Байгаль орчны нөхцөл; • Инженерийн дэд бүтцийн өнөөгийн байдлын судалгаа; • Байршлын хувилбар боловсруулах, оновчтой байршлыг сонгох. 3. Бодлогын шинжилгээ: • Монгол Улсын ачаа, тээвэр логистикийн хөгжил, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн судалгаа; • Тээврийн нэгдсэн үзүүлэлт; • Замын-Үүд боомтын бүс, нутгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө тээвэр логистик, аж үйлдвэрлэлийг дэмжих бодлого; • Тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөгөө; • Бодлогын үр дагавар; 4. Шуудан, логистикийн төвийн дэд бүтцийн төлөвлөлт: • Төслийн талбайн шинжилгээ; • Газар ашиглалтын төлөвлөгөө;

		• Шуудан, логистикийн төвийн үйлдвэрлэлийн хэмжээ, хучин чадал, зэрэглэлийг тооцох; • Барилга, байгууламжийн төлөвлөлт; • Зам, тээврийн сүлжээ төлөвлөлт; • Инженерийн дэд бүтцийн төлөвлөлт; • Цахилгаан хангамж; • Дулаан хангамж; • Усан хангамж; • Холбоо, мэдээллийн сүлжээ; 5. Шуудан, логистикийн төвийн үйл ажиллагааны төлөвлөлт: • Шуудан, логистикийн төвийн үйлчилгээний процессын технологийн дараалал, схемийг төлөвлөх; • Шаардлагатай тоног төхөөрөмжийн төлөвлөлт; • Шуудан, логистикийн төвийн үйл ажиллагааг хангах бүтэц, орон тоо, хүний нөөц, ажиллах хүчний төлөвлөлт; • Үйлчилгээний борлуулалтын төлөвлөлт; 6. Байгаль орчны хамгаалал ба эрсдэлийн менежмент: • Ногоон байгууламжийн төлөвлөлт; • Хог хаягдлын менежмент; • Эрсдэлийн менежмент; • Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн шинжилгээ. 7. Санхүү, эдийн засгийн тооцоолол ба хэрэгжүүлэх арга хэмжээ: • Хөрөнгө оруулалтын тооцоо; ▪ Барилга байгууламж ба тохижилтын хөрөнгө оруулалт; ▪ Зам, тээврийн дэд бүтцийн хөрөнгө оруулалт; ▪ Инженерийн дэд бүтцийн хөрөнгө оруулалт; ▪ Холбоо, мэдээллийн сүлжээний хөрөнгө оруулалт; ▪ Нийт хөрөнгө оруулалт, эргэн төлөгдөх хугацаа; • Төслийн нийт зардал; • Төслийн ур ашгийн тооцоо; • Төслийн эдийн засгийн шинжилгээний үр дүн; • Мэдрэмтгийн байдлын шинжилгээ; • Төслийн эрсдэлийн шинжилгээ, төслийн эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө. 8. Үнэлгээ ба бодлогын зөвлөмж • Санхүүжилтийн арга хэмжээ; • Бодлогын зөвлөмж.
7	Баримт бичиг тавигдах ерөнхий шаардлага	• Шуудан, логистикийн төв нь тээврийн дэд бүтцийн чухал хэсэг учраас холимог тээврийн байгууламжууд (авто зам, төмөр замын), холбоосуудыг тооцоолох; • Техник-эдийн засгийн үндэслэлийг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, журам, дүрмийн хүрээнд боловсруулсан байх; • Техник-эдийн засгийн үндэслэлийг захиалагч талд

		танилцуулан санал, зөвлөмжийг тусгасан байх; • Техник-эдийн засгийн үндэслэлд хөндлөнгийн шинжээчдийг томилуулан дүгнэлт гаргуулсан байх; • ТЭЗҮ боловсруулах явцад цуглуулсан бүх мэдээллийг хавтаслалт файл болгон хүлээлгэн өгөх; • Техник-эдийн засгийн үндэслэлийн тайлбар бичиг, зураг файлуудыг эцсийн хувилбараар Hard disk-нд байршуулан захиалагчид хүлээлгэн өгөх.
8	Техник, эдийн засгийн судалгааны тайлангийн бүтэц	1. Агуулгын хэсэг • Нүүр хуудас • Агуулга; • Хүснэгт, зургийн жагсаалт; • Товчилсон үгийн тайлбар; 2. Танилцуулгын хэсэг • Гүйцэтгэлийн хураангуй; • Төслийн хураангуй танилцуулга; 3. Судалгааны хэсэг • Нөхцөл байдлын шинжилгээ; • Эрэлт, нийлүүлэлтийн шинжилгээ; 4.Төслийн үндсэн хэсэг • Төслийн зорилго, зорилт; • Төслийн бүтээгдэхүүн үйлчилгээ, техник, технологийн шийдэл; • Барилга байгууламж, дэд бүтцийн төлөвлөлт; • Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө; • Төслийн санхүү, хөрөнгө оруулалтын тооцоо; • Төслийн санхүү эдийн засгийн үр ашгийн тооцоо; • Эрсдэлийн шинжилгээ; 5. Дүгнэлт, санал, зөвлөмж 6. Хавсралт.
9	Төслийн тайлангийн үе шат	**<u>Явцын тайлан:</u>** Судалгааны ажлын явцын дэлгэрэнгүй тайланг Захиалагч талд сар бүрийн 1-ний өдрийн дотор танилцуулах. **<u>Эцсийн тайлан:</u>** Энэхүү ажлын даалгаварт тусгагдсан судалгааны ажлуудыг нэгтгэсэн ТЭЗҮ-ийн тайлан болон бусад холбогдох зураг, төсөв, үнэлгээний тайлангуудыг Цахим хөгжил инновац, харилцаа холбооны яам, Монгол шуудан ХК-ын төлөөллүүдээр баталгаажуулж, дэмжсэн байна. Уг судалгааны тайлангуудыг Монгол хэл дээр хэвлэмэл болон файл хэлбэрээр захиалагчид эх хувь 1, хуулбар 2 хувийг хүлээлгэж өгнө. Мөн тоон мэдээлэл, бичиглэлийн болон зураглалын материалыг *.doc, *.xls өргөтгөлөөр, байр зүйн зураглалд суурилсан зураглалын материалыг *.dwg болон *.shp өргөтгөлтэй хүлээлгэн өгнө.

10	Гүйцэтгэгчид тавигдах шаардлага	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулна.
11	Төсөл хэрэгжүүлэх хугацаа	Судалгааны ажлыг Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулснаас хойш 4 сарын дотор хийж гүйцэтгэнэ.

ТАНИЛЦСАН:

БТГ-ЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.БАТЗАЯАТ

БОЛОВСРУУЛСАН:

БТГ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.ТУНГАЛАГ